

Ремикон ХК (RMC.MSE)

Салбар: Аж үйлдвэр

2013/ II сар

Хувьцааны үнэ



Үнэт цаасны үзүүлэлтүүд

Симбол	RMC
Хувьцааны код	530
Нийт гаргасан хувьцаа	78,679,464
Зах зээлийн үнэ 2013.02.19 (төгрөг)	190
Зах зээлийн үнэлгээ 2013.02.19 (тэрбум төгрөг)	14.9
52 долоо хоног- их/бага (төгрөг)	228 / 170
ISIN код	MN00RMC05304

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

	2010	2011
Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	6.35	10.67
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)	0.42	1.85
Биет бус хөрөнгө ба өр төлбөр (тэрбум төгрөг)	1.11	3.95
Эзэмшигчийн өмчийн дүн (тэрбум төгрөг)	6.28	9.26
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	5.36	23.51
Үнэ ашгийн харьцаа (P/E)	12.32	5.71
Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B)	0.99	1.57
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.07	0.17
Эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE)	0.07	0.20
Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)	1.6	5
Ногдол ашгийн өгөөж	2	4
Дундаж хувьцааны үнэ (төгрөг)	66	134
Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг)	5.2	10.56
Дансны үнэ (төгрөг)	67	85
Үнийн хэлбэлзэл	4.62	3.5

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

Судалгааг бичсэн:

Цэдэвдорж ЧИМГЭЭ,

Судалгааны багийн ахлагч

chimgee@standardinvestment.mn

T +976 7011 4433

M +976 99066293

Бямбаа МӨНХТУЯА,

Судалгааны ажилтан

munkhtuya@standardinvestment.mn

T +976 7011 4433

M +976 99027432

КОМПАНИЙН ТОЙМ

Танилцуулга

Ремикон ХК 2008 онд байгуулагдсан бөгөөд Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжин нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь бетон зуурмаг, барилгын материал, бетон хийц, хөнгөн блокны үйлдвэрлэл, шохойн олборлолт, цементийн үйлдвэрлэл бөгөөд зам, гүүр, барилгын салбарт хэрэглэгдэх машин механизмын түрээсийн үйлчилгээг үзүүлдэг. Ремикон ХК нь хүний нөөцөө ахмад туршлагатай мэргэжилтнүүд болон чадварлаг залуусаар бүрдүүлсэн. Үйлдвэрийн технологи, чанарын хяналтын албанд нь Монгол Улсын зөвлөх инженер, магистр, бакалавр зэрэгтэй инженер, техникийн 40 гаран ажилтан ажиллаж байна.

Менежмент

Ремикон ХК нь нийт 78,679,464 ширхэг хувьцаа гаргасан. 2012 оны 12 дугаар сард ҮЦТТХТ-ийн мэдээлснээр 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид 3 бөгөөд тэд нийт 48,572,581 ширхэг буюу 61.7%-ийг, бусад хувьцаа эзэмшигчид 1,203 ба нийт 30,106,883 ширхэг хувьцаа буюу 38.3%-ийг эзэмшиж байна. МХБ-ийн мэдээлснээр тус компанийн гол хувьцаа эзэмшигчид нь: Х.Ганхуяг, Ремикон ХК, ФРОНТИЕР ХХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Х.Ганхуяг

Ноён Хассуурийн Ганхуяг нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. 1994-1998 он МУИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн. 1999-2001 онд БНСУ-ын Үндэсний академид магистрийн зэрэг хамгаалсан. 1996-1999 онд Сөүл группд офис менежер, Жуулчин корпорацид оффис менежерээр ажиллаж байгаад 2001 оноос Хера группыг үүсгэн байгуулж, ерөнхий захирлаар ажиллаж байжээ. 2008 оноос Ремикон ХК-ийн ТУЗ-ын даргын үүргийг гүйцэтгэж байна. Мөн 2010 оноос Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ТУЗ-ын гишүүнээр ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал Э.Мөнхсайхан

Ноён Энхбаярын Мөнхсайхан нь 1980 онд төрсөн. ОХУ-д эдийн засагч мэргэжлээр суралцаж төгссөн ба бизнесийн хөгжил, судалгаа маркетингийн чиглэлээр ажилласан туршлагатай. 2009 оноос хойш Ремикон ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Зах зээлийн мэдээлэл



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монголын барилгын салбар шилжилтийн эдийн засгийн үед зогсонги байдалд ороод байсан ба 2001 оноос эхлэн сэргэж, 2008 он хүртэл эрчимтэй хөгжсөн ба Монгол Улсын гадаад худалдааны таатай нөхцөл, банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал болон хүн амын орлогын өсөлт нь барилгын салбарын хөгжилд эергээр нөлөөлсөн байна. 2002 оноос хойш тасралтгүй өндөр өсөлттэй байсан ДНБ 2009 онд харьцангуй бага өссөн хэдий ч ДНБ-ний хэмжээ нэмэгдэх тутамд барилгын салбарын бүтээж мөн өсч ДНБ-нд эзлэх барилгын салбарын хувь хэмжээ 1.3%-1.9% байжээ. 2008-2012 онд бетон зуурмаг ба хөнгөн бетоны үнийн өсөлт мөн 2%-31% байж 77,000-145,000 төгрөг болсон байна. Барилгын чанар, байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг тэсвэрлэх чадварыг харгалзан 2006 онд Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар гар аргаар үйлдвэрлэсэн бетон зуурмагийг барилгад ашиглахыг хориглосон байна. Тиймээс стандарт хангасан бетон зуурмагийн үйлдвэрлэлийн хэрэгцээ өсөн нэмэгдсэн байна.

Компанийн өсөлт, хөгжил

Ремикон ХК нь Монголын томоохон бетон зуурмагийн үйлдвэр бөгөөд компанийн зорилго нь олон улсын стандартад нийцсэн бетон зуурмаг үйлдвэрлэх явдал юм. Ремикон ХК нь 2011 оны байдлаар Монгол Улсын бетон зуурмагийн зах зээлийн 8 орчим хувийг эзэлж байсан. Барилгын технологийн үйл ажиллагаа цутгамал каркасан барилгад шилжиж, шал, тааз, ханыг шууд газар дээр нь цутгах технологийг өргөн ашигладаг байна. Компанийн удирдлагын баг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээ 2010 онд 5.2, 2011 онд 2.3 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөн ажилласнаар тодорхой дэвшилд хүрсэн байна. Ремикон ХК нь 2012 онд 5 төрлийн бетон үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн хүчин чадал нь цагт 150 м³ бетон байжээ. 2012 онд нийт 127,445 м³ бетон үйлдвэрлэж 20 орчим тэрбум төгрөгний борлуулалт хийн, салбартаа тэргүүлсэн байна. Ремикон ХК нь 2013 оны эхээр үйлдвэрийн 2 дугаар шугамыг ашиглалтад

оруулбал үйлдвэрлэлийн хүчин чадал цагт 300 м³ хүртэл өсөхөөр байна. Мөн орон нутагт бетон зуурмаг үйлдвэрлэх зөөврийн үйлдвэр нь захиалгаар үйлдвэрлэлээ эхлүүлэхэд бэлэн болж, энэ оны 1 дүгээр улиралд багтан ашиглалтанд орохоор юм. Түүнчлэн жилд 200,000 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий цементийн үйлдвэрийг 2013-2014 онд бариж дуусгахаар төлөвлөж байна. Цементийн үнэ, импортын хэмжээг дээрх хүснэгтэд харуулав. Ремикон ХК-ийн цементийн үйлдвэр ашиглалтад орсноор өөрийн эзэмшилдэх шохойн чулууны ордыг ашиглалтанд оруулахаар судалгааны ажил хийгдэж байна. Шинэ цементийн үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын зах зээл рүү импортлогдож буй цементийн хэмжээг бууруулах, дотоодын цементийн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах ач холбогдолтой юм.


Дүгнэлт

Өсөн тэлж буй Улаанбаатар хотод барилгын гол түүхий эд үйлдвэрлэгч Ремикон ХК-ийн 2011 оны санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч, цэвэр ашгийн хэмжээ 0.42 тэрбум төгрөгөөс 1.85 тэрбум төгрөг болж, нэгж хувьцааны ногдол ашгийн өгөөж 2%-иас 4% болж өссөн байна. 2012 онд RMC хувьцааны үнийн хэлбэлзэл нь 2.1% байж өмнөх онуудаас хэлбэлзэл нь багассан, мөн ТОП-20-д багтах хувьцаануудаас бага хэлбэлзэлтэй 4 дэх хувьцаа болсон байна. Энэ нь тухайн хувьцааны үнийн байдал харьцангуй тогтворжиж байгааг харуулж байна.

RMC хувьцааны арилжааны идэвхийг судлахад 2011 онд 241 өдрийн арилжаагаар нийт 33,325,226 ширхэг арилжигдаж, хамгийн их арилжигдсан хувьцаа, 2012 онд 200 өдрийн арилжаагаар 7,596,723 ширхэг хувьцаа арилжигдан 3-т орсон байна. Энэ нь RMC хувьцаа нь хөрвөх чадвар сайтай, эрсдэл багатай болохыг харуулж байна.

2012 онд тус компанийн борлуулалтын хэмжээ нэмэгдсэн, мөн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэнтэй холбогдон хувьцааны үнэ 2013 онд 250-290 төгрөг болно гэж таамаглаж байна. Иймээс харилцагч та RMC хувьцааг анхааралдаа авч хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл манай брокер дилерийн албатай холбогдоно уу.

Цементийн үнэ, импортын хэмжээ



Он	Монгол улсын үйлдвэрлэсэн цементийн үнэ, M-500, 50 кг	Хятад улсын үйлдвэрлэсэн МУ-д борлуулагдаж буй цементийн үнэ, M-500, 50 кг	Импортолсон цементийн хэмжээ, мян.тонн
2008	6496	6875	643.7
2009	5327	7042	307.8
2010	5800	6750	455.9
2011	6925	8125	785.9
2012	9050	8750	

Холбоо барих

Хаяг:

Стандарт Инвестмент ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жигжиджавын гудамж 5/3

Шуудангийн хайрцаг:

Төв шуудан, Улаанбаатар 15160,
Хайрцагны дугаар 1487 **Утас:** +976 7011 4433

Факс: +976 7011 4433

www.standardinvestment.mninfo@standardinvestment.mn

Мэдэгдэл

Энэхүү судалгааг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд бүх мэдээллийг найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт Инвестмент ХХК нь эдгээр мэдээллийг үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн энэхүү мэдээллийг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт Инвестмент ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү мэдээлэл нь ямар нэгэн үнэт цаасны худалдан авах, худалдах санал буюу хөрөнгө оруулалтын зөвөлгөө биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно. /Стандарт Инвестмент ХХК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Мэдээллийг зөвхөн хаягласан хувь хүн болон албан байгууллагын хэрэглээнд зориулсан ба Стандарт Инвестмент ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр цааш нь дамжуулах, түгээх, хуулбарлахыг хариглоно.

© 2013 Standard Investment LLC